



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017. 03. 15. № 02-01/183.

танай _____ -ны № _____ -т

Даралтат савны ашиглалтын
байдалд шалгалт хийх,
баталгаажуулалтад хамруулах



Нэг. Шалгалтын зорилго

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг даралтат сав бүхий үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын даралтат савны суурилуулалт, ашиглалт, техникийн магадлал, баталгаажуулалтын байдалд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Эрчим хүчний тухай” “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулиуд, “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг “Даралтат савны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас” 5.10-аар шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах эрх зүйн акт шийдвэрүүдийг гаргаж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Хяналт шалгалтанд Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг хий хадгалах даралтат сав, шугам хоолой ашиглагч үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд, тэдгээрийн инженер техникийн ажилтнууд хамрагдана.

Гурав. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Хяналт шалгалтыг Эрчим хүчний /газрын тос, хий/ хяналтын улсын ахлах байцаагч Т.Мөнхболд ахлан, улсын байцаагч Б.Золжаргал нар 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгалтын чиглэл

1. Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд;

005050006378

2. Хий хадгалах даралтат сав, тоног төхөөрөмж, шугам хоолойн суурилуулалт, угсралтыг зураг төслийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд;

3. Хий хадгалах даралтат сав, тоног төхөөрөмжийг дүрмийн шаардлагад нийцсэн байр, талбайд байрлуулсан эсэхэд;

4. Хий хадгалах даралтат савыг улсын бүртгэлд хамруулж ашиглах зөвшөөрөл авсан эсэхэд;

5. Даралтат савны хийц нь тооцоолж тогтоосон ашиглалтын хугацаанд ашиглалтын найдвартай, аюулгүй байдлыг хангасан байхын зэрэгцээ түүнд техникийн магадлал, засвар, цэвэрлэгээ, угаалга, үлээлгэ хийх, түүнийг хоослох, мөн металл, гагнасан холболтод ашиглалтын үед шалгалт хийх боломжийг хангасан эсэхэд;

6. Хий хадгалах даралтат сав, шугам хоолойд дүрэмд заасан хугацаанд гадаад, дотоод үзлэг, оношлогоо, магадлагаа хийлгэдэг эсэхэд;

7. Даралтат савны бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтан ба даралтат савны ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг тушаалаар томилсон эсэхэд;

8. Даралтат савтай харьцаж ажилладаг ажилтнуудыг дүрмийн дагуу мэргэжлийн сургалтад хамруулж, үнэмлэхжүүлсэн эсэхэд;

9. Дотоодын хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхэд тус тус шалгалт хийж зохих эрх зүйн акт шийдвэрүүдийг гаргаж биелэлтийг хангуулж ажиллана.

Тав. Шалгалтын дүн

1. Шалгалтын дүнг хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулан, гарсан шийдвэрийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

2. Шалгалтын дүнгийн талаар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан "Олон нийтэд мэдээлэл түгээх журам"-ын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ЭРЧИМ ХҮЧНИЙ /ГАЗРЫН ТОС, ХИЙ/ ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Т.МӨНХБОЛД

